



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Лхагва гараг, 2023 оны 04 дугаар сарын 26-ны өдөр

Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

Хувьцаа эзэмшигчид:	
Голомт Файнэншл Групп ХХК	
Свисс-МО Инвестмент АЖ	
Голомт Инвестмэнд Лимитэд	
Бодь Интернэйшнл ХХК	
Бусад	
Хурлын ирц: 88.45 хувь	
Хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдээлэл танилцуулахаар хуралд оролцогчид:	
Гүйцэтгэх Захирал	Норихико Като
ТУЗ-ийн гишүүн	Д.Мөнхтөр
PwC Mongolia удирдах партнер	Шаукат Тапия
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	З.Солонго
Дотоод аудитын газрын захирал	А.Одонбаатар
Хуулийн хэлтсийн захирал	Г.Ганбат
Тооллогын комисс:	
Ерөнхий аудитын хэлтсийн захирал	Б.Баатар (Дарга)
Төлөвлөлт үнэлгээний хэлтсийн захирал	Г.Гүрбазар (Гишүүн)
Хуулийн хэлтсийн захирал	Г.Ганбат (Гишүүн)
Хуулийн хэлтсийн хуульч	Т.Хүүбаяр (Гишүүн)
Бизнес хамтын ажиллагааны албаны ахлах бизнес шинжээч	Э.Хулан (Гишүүн)
ТУЗ-ийн ажлын алба, Хөрөнгө оруулагчдын харилцаа хариуцсан менежер	О.Номуншүр (Гишүүн)
Ахлах корпорэйт менежер	Б.Мөнхжаргал (Нарийн бичиг)
Хурал 09:15 цагт эхлэв.	
Голомт Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын танхимд болон golomtbank.com веб хуудсаар шууд дамжуулж, танхим цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулагдав. Хуралд Голомт Банк ХК-ийн ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд оролцов. Хурлыг жижиг хувьцаа эзэмшигч болон Голомт банкны Ерөнхийлөгч Г.Ганболд даргалж, хурлыг 09:15 минутад албан ёсоор нээв. Хурлын дарга Г.Ганболд: Бид өнөөдөр Голомт Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулахаар та бүхнийг урьсан. Энэхүү ээлжит хуралд хүрэлцэн ирсэн манай эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч та бүхэнд талархлаа илэрхийлье. Бид хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг энэ оны 2 сарын 2-ны өдөр мөн энэ зааланд хийсэн. Мөн өнөөдрийн энэ хурлын адил танхим болон онлайн горимоор хийж амжилттай дуусгасан, харин одоо санхүүгийн жилийн үр дүн гарч, хөндлөнгийн аудитын үр дүн гарч баталгаажсан ба компанийн тухай хууль болоод нээлттэй хувьцаат компанийн дүрэмд зааснаар бид ээлжит хурлаа 4 сарын 30-аас өмнө хийх ёстой. Энэ өдрүүдэд та бүхэн анзаарсан бол бүх нээлттэй компаниуд 30-ны өдрөөс өмнө ээлжит хурлаа хийж 2022 оны ажлынхаа үр дүнг хэлэлцээд хууль заасан бусад асуудлыг хэлэлцэж байгаа. Голомт банкны хувьд мөн адил өөрийн дүрэм болоод хуульд заасны дагуу ТУЗ-өөс хуралд бэлтгэх тогтоол шийдвэрүүд гарсан. Хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэг, хурлаар хэлэлцэх асуудлын материалууд урдчилан манай цахим хуудас мөн манай үнэт цаасны компаниуд болох Инвекор капитал, Голомт капиталаас та бүхэнд мэдээлэл, и-мэйлийн дагуу хүргүүлсэн. Өнөөдрийн хуралд оролцож байгаа манай хүндэт хувьцаа эзэмшигчдэд өнөөдрийн хурлаар хэлэлцэх 7 материалтай танилцах боломжийг 04 сарын 14-21 өдрийн хооронд бүрэн олж авсан, танилцаж ирсэн байх гэж бодож байна.	



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Голомт банк өнгөрсөн оны 12 дугаар сард IPO хийж нээлттэй хувьцаат компани болохдоо бид 21,000 гаруй хувьцаа эзэмшигчидтэй болж өнөр болсон. Нээлттэй хэлбэр рүү шилжсэнээр хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэж компанийн засаглал улам сайжрах үндэс бүрдэж, илүү нээлттэй ажиллах бололцоо бүрдсэн. Үүнээс хойш өнөөдрийн хурлаар бид нийт 7 асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулахын тулд бид тооллогын комиссыг урьдчилж томилсон. Тооллогын комиссыг нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй, Голомт банкны Дотоод аудитын газрын хэлтсийн Б.Баатар захирлаар ахлуулсан баг байна. Гишүүдээр Санхүү Удирдлагын газрын хэлтсийн захирал Гүрбазар, Хуулийн хэлтсийн захирал Ганбат, хуульч Хүүбаяр, манай ажилтан Хулан, мөн ТУЗ-ийн ажлын албын ажилтан Номуншүр ажиллах болно. Тооллогын комисс бол эхний ээлжид хурлын ирцийг хуульд нийцсэн эсэх ирц бүрдсэн эсэхээр бидэнд мэдээлэл өгөх ёстой. Би дахин давтаж хэлэхэд өнөөдөр энэ танхимаас тодорхой техник тоног төхөөрөмжийн дагуу YouTube сувгаар дамжуулаад бусад хувьцаа эзэмшигчдэдээ хурлын үйл ажиллагааг онлайнаар мөн давхар хүргэж байгаа. Онлайнаар дамжуулж байгаа хуралд хэдэн хувьцаа эзэмшигч оролцож байна хэр их хүн саналаа өгөх бололцоотой байна гэдгийг бүртгээд хянах боломжтой байгаа. Танхимд болоод ар талд манай техникийн баг ажиллаж байна. Энэ дамжуулалтыг саадгүй хувьцаа эзэмшигчдэд хүргэх үүрэг бүхий ажиллаж байна. Хоёр дахь нь бол энэ танхим. Энэ танхим 80 орчим хувийн дүүргэлттэй байна. Энд бол зарын дагуу өөрсдөө биечлэн ирж хуралд оролцох хүсэлтээ өгсөн манай хувьцаа эзэмшигчид цугласан байна. Ингээд хурлыг албан ёсоор нээснийг мэдэгдээд ТУЗ-ийн тогтоолын дагуу миний бие энэ хурлыг даргалан явуулна, Голомт банкны ерөнхийлөгч Ганболд. Мөн тус банкны Гүйцэтгэх захирал Ноён Норихико Като захиралтай хамтарч бид хоёр хурлыг удирдах болоод хурлын ажиллагааг зохион байгуулахад оролцож ажиллана. Тооллогын комиссын дарга Б.Баатар захирлыг өнөөдрийн хурлын ирцийг танилцуулахыг урьж байна.

Тооллогын комиссын дарга Б.Баатар: Нийт хувьцаа эзэмшигч та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. 2023 оны 4 сарын 26-ны өдрийн 09 цагаар тасалбар болгон тооллогын комиссын тогтоолыг танилцуулъя. Компанийн тухай хуулийн 67-р зүйлийн 67.3.1, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Голомт банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрөөр нийт энгийн 808,657,306 ширхэг хувьцаанаас 715,264,905 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 88,45 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд бүртгүүлсэн. Үүнд зайнаас холбогдсон, биечлэн ирсэн байх тул хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай. Тооллогын комиссын дарга Баатар, гишүүд Гүрбазар, Ганбат, Хүүбаяр, Хулан, Номуншүр. Баярлалаа.

Хурлын дарга Г.Ганболд: Баатар захиралд баярлалаа. Манай хувьцаа эзэмшлийг бүрдүүлж буй гол багцыг эзэмшиж байгаа Голомт санхүүгийн групп болон Бодь Интернэшнл компаниудын төлөөлөл зааланд хүрэлцэн ирсэн. Мөн IPO-ийн үр дүнд шинээр нэмэгдсэн 20,000 орчим хувьцаа эзэмшигчид байна. Ирцийг та бүхэнд танилцууллаа 80 гаруй хувьтай байгаа учир эрх зүйн хувьд хурлыг эхэлж явуулах бүрэн бололцоотой болж байна. Хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя, хурлын дэгийг 2 дахь удаагаа танилцуулах гэж байна. Та бүхэн и-мэйлээр болоод манай цахим хуудас, дан системээр нэвтэрч хурлын материалтайгаа танилцахад дэлгэц дээр харуулж байгаа дэг та бүхний гар дээр очсон. Өнөөдөр 7 асуудал хэлэлцэнэ.

1. Голомт Банк ХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Голомт Банк ХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг танилцуулах, батлах;
3. Голомт Банк ХК-ийн 2022 оны аудитлагдсан санхүүгийн үр дүн-Хөндлөнгийн аудитын дүгнэлтийг танилцуулах;
4. 2022 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах;
5. 2022 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ажлын тайланг танилцуулах, 2023 оны төсвийг батлах;
6. Төлөөлөн Удирдах Зөвлөлд нэр дэвшигчдийн танилцуулга;
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын төслийг танилцуулж, батлах;

Албан ёсоор эдгээр асуудлыг хэлэлцэхээр ТУЗ-өөс шийдвэрлэсэн. Өнөөдрийн хурлыг тодорхой дэгийн дагуу хуульд болон дүрэмд заасны дагуу зохион байгуулна. Хурлыг 09:00 цагт эхлээд үдээс өмнөдөө багтаан хуралдуулахаар байгаа.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Хурлын дэгийг танилцуулав:

- Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрт заасан эрх бүхий албан тушаалтан хурлыг удирдан явуулна.
- Хурлын ирцийг Тооллогын комисс танилцуулснаар Хурлын дарга албан ёсоор хурлыг нээнэ.
- Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд тусгагдаагүй асуудлыг хэлэлцэхгүй.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг тогтоосон цагийн хуваарийн дагуу явуулна.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг мэргэжлийн хөндлөнгийн компаниар бичлэг хийлгэж цахим хэлбэрээр шууд дамжуулалт хийх ба энэхүү бичлэг баримт болон компани дээр хадгалагдана. Өөр ямар нэгэн хэлбэрээр дуу, дүрс бичлэг хийхгүй.
- Хувьцаа эзэмшигч хурлыг аливаа хэлбэрээр үймүүлэх, зориуд саатуулах, бүдүүлэг үг хэллэг ашиглан бусдыг доромжлох, бусдын нэр төрийг гутаах, гүтгэхийг хориглоно.
- Хурлын дэгийг зөрчсөн хувьцаа эзэмшигчид эхний удаа Хурлын дарга урьдчилан сануулна. Зөрчлийг дахин гаргасан хувьцаа эзэмшигчийг Хурлын даргын зөвшөөрлөөр Зохион байгуулах комисс хурлаас гаргах арга хэмжээг авна.
- Хурлаар хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэж дууссаны дараа санал хураалт явуулж, Тооллогын комисс хэлэлцсэн асуудал тус бүрээр хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг нэгтгэж, Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулна. Та бүхэн харж байна зааланд манай улаан дүрэмт хувцастай ажилчид байна бүгд таблеттэй зогсож байгаа. Таны гар утас санал хураалтад оролцоход ямар нэгэн бэрхшээл гарвал манай зохион байгуулагч нарт хандаарай.
- Хурлын дарга Тооллогын комиссын тогтоолд үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг танилцуулж, хурал хаасныг мэдэгдэнэ.

Хурлын дарга Г.Ганболд: Хурлын дэг бол компанийн тухай хууль болоод Санхүүгийн Зохицуулах Хороо-с гаргасан тогтоол, манай компанийн журамд бүрэн нийцэж байгаа. Хурлаар хэлэлцэх асуудал бүр дээр хэрхэн санал өгөх талаар манай тооллогын комиссын дарга та бүхэнд дэлгэрэнгүй танилцуулна. Санал өгөх процесс манай хурлын чухал хэсэг шийдвэр гаргах процесс байгаа.

Тооллогын комиссын дарга Б.Баатар: Санал өгөх заавар алхамууд энгийн. Онлайнаар буюу та бүхэн Голомт банкны албан ёсны цахим хуудсаар саналаа өгөх боломжтой. Хөрөнгө оруулагчид хэсэгт нэвтэрч орохоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал гэсэн цонх гарч ирнэ. Ороод 2 сонголттой байгаа хэрэв та Голомт банкны харилцагч бол интернэт банкны эрхээр мөн ДАН системээр нэвтрэх боломжтой. ДАН систем рүү орохоор 3 сонголт байгаа, нэг удаагийн кодоор, тоон гарын үсэг мөн банкны интернэт банкны нэвтрэх мэдээлэл ашиглах гэсэн. Ганболд ерөнхийлөгч хэлсэн байгаа та бүхэн ямар нэгэн электроникийн саатал гарвал манай банкны ажилтнууд та бүхэнд туслахаар байгаа. ДАН системээр орж байгаа учир өөрийн мэдээллээ өгөхийг зөвшөөрөх хэрэгтэй товчлуур бий. Нэвтэрч ороод манай санал хураалтын цонх нээгдэнэ. Хувьцаа эзэмшигчдийн хурал онлайн буюу шууд дамжуулагдаж байгаа. 2 аргачлалаар саналаа өгнө эхний 3 асуудлыг ердийн санал хураах аргаар саналаа өгнө, Зөвшөөрсөн, Татгалзсан, Түдгэлзсэн. Санал өгсний дараа “Амжилттай” гэж хадгалагдана. Сүүлийн асуудал болох ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо кумулятив аргаар сонгож баталгаажуулна. Энэ аргын давуу тал бол нэг нэр дэвшигч болон олон нэр дэвшигчид санал өгөх боломжтой байгаа. Та бүхэн өнөөдрийн 9 нэр дэвшигчдэд саналаа өгөөд санал илгээх товч дээр дарахад мөн “Амжилттай” гэж хадгалагдана. Ингээд та бүхний саналыг онлайнаар хүлээж авч бүртгэнэ. Баярлалаа.

Хурлын дарга Г.Ганболд: Санал өгөхтэй холбоотой асуулт байна уу нийт 4 асуудлаар шийдвэр гарна. Батлах асуудлуудыг танилцуулсны дараа, бүх асуудлыг хэлэлцэж дуусахыг хүлээлгүйгээр саналаа өгөөд явах бололцоотой. Асуулт байхгүй байна гэж ойлголоо. Хурлын хэлэлцэх асуудлын дарааллын дагуу эхний асуудал болох Голомт Банкны 2022 оны жилийн үйл ажиллагаа болоод санхүүгийн үр дүнгийн талаарх танилцуулгыг Гүйцэтгэх захирал Норихико Като та бүхэнд хүргэнэ.

Хэлэлцэх асуудал 1. Голомт банк ХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга.

Танилцуулсан нь:



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

(Норихико Като англи хэл дээр тайланг танилцуулж, шууд орчуулгатай явав)

Гүйцэтгэх захирал Норихико Като: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа та бүхэнд маш их баярлалаа. Менежментийн зүгээс одоо 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах гэж байна.

- Макро эдийн засгийн тойм танилцуулав. 2021 онд Монгол улсын эдийн засгийн өсөлт бага зэрэг буурсан 1.6%-тай байсан бол 2022 онд эдийн засгийн өсөлт 4.8% болсон. Эрчим хүч импортын барааны өртгөөс хамаарч 2022 оны инфляц 13.2% болж өссөн байна. Ковидоос шалтгаалаад Засгийн газраас мөнгөний нийлүүлэлтийг ихэсгэсэн байгаа. Мөн эрчим хүчний өртөг болон Орос Украины дайн зэрэг хамаарлуудаас шалтгаалж инфляц өссөн. Хамгийн өндөр инфляцтай байсан үе нь 2022 оны 6 сард 16%-иас дээш гарсан байна. Инфляцыг бууруулахын тулд мөн төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн сулралыг бууруулахын тулд Монгол банкнаас 5 удаагийн шийдвэрээр бодлогын хүүг 6-13% болгож өсгөсөн байна. Та бүхэн санаж байгаа байх 2022 онд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 21%-иар буюу маш их суларсан. Оны эцэст ам.долларын ханш 3,400 давсан байгаа. Өнгөрсөн онд системийн нөлөө бүхий банк IPO гаргасан Төрийн банк болон Голомт банк. IPO гаргахаас өмнө нөлөө бүхий банкнуудад активын чанарын үнэлгээ хийгдсэн байгаа. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг харуулсан байна. Энэ өсөлт нь улирал тутам өсөөд явж байгаа, цаашид үргэлжлэнэ гэж найдаж байгаа. Доод зураг дээр тасархай зураасаар бодлогын хүүг харуулж байна. Бодлогын хүү 13% байна. 2023 оны турш энэ 13% хадгалагдана гэж харж байна. Мөн мөнгөний нийлүүлэлтийг харуулсан байна. Мөнгөний нийлүүлэлт 29.6%-д хүрээд одоо бол 6.5%-тай байна. Мөн үүн дээр инфляц 13.2%-тай харагдаж байна.
- Голомт банкны аудитлагдсан санхүүгийн тайланг харуулж байна. Түрүүн ярьсан макро эдийн засгийн хэцүү орчин нөхцөлд Голомт банк маш сайн ажилласан. Аудитлагдсан санхүүгийн тайлангаас голлох чухал тоон үзүүлэлтийг та бүхэнд дэлгэрэнгүй танилцуулъя. Цэвэр ашиг 2022 онд 116.5 тэрбум төгрөг гарсан ба өмнөх 3 жилтэй харьцуулахад онцгой өндөр өсөлт мөн. Хэрхэн бид энэ амжилтад хүрсэн талаар нэг бүрчлэн тайлбарлах хүсэлтэй байна. Харилцах хадгаламжийн хэмжээ 5.1%-иар өсч 5.7 их наядад хүрсэн. Цэвэр зээл 10.7 %-иар өсч 3.7 их наядад хүрсэн. 10.7 гэдэг тоо системийн нөлөө бүхий банкнуудтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт байгаа. Дараагийн үзүүлэлт нийт өөрийн хөрөнгө байгаа. Оны сүүлд буюу 12 сард IPO гаргасан. Нэгдүгээрт та бүхний дэмжлэгээр, хоёрдугаарт цэвэр ашиг нөлөөлж манай нийт өөрийн хөрөнгө 862 тэрбум төгрөг болсон. 2021 оны эцэст 659 байсан бол одоо 862 тэрбум төгрөг болсон байна. Одоо бид маш хүчтэй суурь хөрөнгөтэй болсон. Цэвэр хүүгийн орлого 36.7%-иар өсөөд 385.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Системд нөлөө бүхий банкнуудын 2 дугаарт буюу Хаан банкны дараа явж байгаа гэсэн үг. Дараагийн үзүүлэлт бол цэвэр хүүгийн бус орлого. Энэ маш чухал үзүүлэлт байдаг арилжаа болон шимтгэлтэй холбоотой өнгөрсөн жил 191.6%-иар өсөөд 141.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. Валют арилжааны ашиг орлого нөлөөлсөн. Өнгөрсөн онд 27 тэрбум төгрөгийн орлого олж байсан бол 2022 онд бид 65 тэрбум төгрөгийн орлогыг арилжаанаас олсон. Нэгдүгээрт валют арилжаа маш идэвхтэй явсан байгаа үүнтэй холбоотой. Хоёрдугаарт валютуудын эсрэг төгрөгийн сулрал нөлөөлсөн, мөн Орос Украины дайнаас хамаараад бусад төрлийн валют арилжаа маш идэвхтэй явсан энэ дээр евро, юань зэрэг арилжаа маш идэвхтэй болж ирсэн. Энэ боломжийг манай багийнхан маш сайн ашиглаж чадсан. Бид үйл ажиллагааны зардлыг маш сайн удирдсан. Үүний ачаар бид үйл ажиллагааны ашгийг 317.2 тэрбум төгрөгт хүргэсэн. Энэ нь Голомт банкны түүхэн дээд амжилт мөн. Дараагийн мөр бол сан үнэлгээний зардал байна. Чанаргүй зээлүүдийг шийдэх зорилготой бид бүртгээд явж байх ёстой бүртгэлийн шинж чанартай зардал байдаг. Өмнөх жилүүдэд бид Монголбанкны журмын дагуу бүртгэлээ өндөр дүнгээр хийгээд явж байсан. Үл ажиллагааны ашиг 317.2 тэрбум гарсан гэдгийг баяртайгаар дуулгахаас гадна бид 2022 онд баланс дээр байгаа чанаргүй зээлийг бууруулахад хүчин чармайлт гаргаж ажилласан. Балансыг илүү цэвэр болгосон.

Сан үнэлгээний зардал дээр бүртгэсэн 158.1 гэдэг нь өндөр харагдаж байж магадгүй гэхдээ үйл ажиллагааны ашиг 317.2 гарсны ачаар цэвэр ашиг 116.5 тэрбум төгрөг болсон. 116.5 тэрбум гэдэг бол өмнөх оноос 4.5 дахин өссөн үзүүлэлт юм. Үүний ачаар манай банкны харьцаа үзүүлэлт, индексүүд өссөн байгаа. Үүний тод илрэл өөрийн хөрөнгийн өгөөж гэдэг үзүүлэлтээр харагдаж байгаа, 19.5 болсон байна. Дараагийн мөр бол цэвэр хүүгийн ахиуц байна. Зээлийн хүүгээс депозитын хүүг хасаад гаргадаг тоо биш. Энэ бол цэвэр хүүгийн орлого цэвэр хүүгийн зардал



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

гээд зүйлүүдийг оруулдаг. Энэ нь өндөр гарсан нь үнэт цаасны орлогоос орсон ашиг нөлөөлсөн байгаа. Дараагийн үзүүлэлт зардал орлогын харьцаа. Зардлаа төсөв төлөвлөгөөний хүрээнд маш сайн хянаж ажилласан. Энэ үзүүлэлт 33.3% болсон. 41.5-аас 33.3 болж буурна гэдэг бол маш өндөр үзүүлэлт юм. Сүүлийн гурван мөр зохистой харьцааны үзүүлэлтийн талаар танилцуулъя. IPO гаргасан мөн цэвэр ашгаас шалтгаалаад нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ 17.9 болж өссөн байгаа. 2-р мөр дээр нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ үзүүлэлтийг Монголбанкаас маш чухалчилж үздэг. Системд нөлөө бүхий банкуудыг 13% болон түүнээс дээш байх шаардлагыг тавьдаг. Манай банк 13-аас 17.9%-д хүрсэн байна. Төлбөр түргэн гүйцэтгэх харьцаа бол зохицуулагч байгууллагаас тавьж байгаа шаардлага бол 25% байдаг. Манай банкны хувьд 2022 оны эцсээр 35.3%-тай гарсан. Цаашид бид 30% дээр барихаар төлөвлөж байна. Би сая 2022 оны үзүүлэлтийг ярилаа та бүхэн 2023 оны үзүүлэлтийг бас сонирхож байгаа байх. Танилцуулгын сүүлийн хэсэг рүү бас гарна. Энэ жил хүүгийн түвшин өндөр хэвээрээ байна гэж харагдаж байна. Мөн гадаад валютын ханш тогтвортой байна гэсэн таамагтай байна. Өнгөрсөн жилийн нөхцөл байдлаас өөр байгаа тийм учир бид өнгөрсөн жил арилжааны ашиг, орлого өндөр байсантай ижил хэмжээний ашиг орлогыг арилжаанаас олж чадахгүй гэж үзэж байгаа. Өнгөрсөн жил бид 63 тэрбум гэж төлөвлөж байсан бол энэ жил 39 тэрбум гэж төлөвлөсөн байгаа. Гэхдээ бид бизнес төлөвлөгөө дээрээ зээлийн өсөлтийг 13.7%, депозитын өсөлтийг 8.1%-иар өснө гэж төлөвлөсөн байгаа. Өндөр өсөлт харуулна гэж төлөвлөсөн. Тайлант жилийн сайн мэдээ гэвэл баланс дээр байгаа чанаргүй зээл хөрөнгүүдийг бууруулахад хүчин чармайлт нэлээн гаргасан. Баланс илүү цэвэр болсон. Сан үнэлгээний зардал бүртгэдэг зардал энэ жил маш бага 17.3%-иар төлөвлөсөн. Үүн дээрээ үндэслээд манай төлөвлөж байгаа цэвэр ашиг 140 тэрбум төгрөг.

- Өөрийн хөрөнгийн өгөөж 2023 онд 16.9% гэж төлөвлөгдсөн. Өөрийн хөрөнгийн өгөөж гэдэг бол дундаж өөрийн хөрөнгө дээр тулгуурлаж гардаг үзүүлэлт байгаа. IPO хийхээс өмнө манай өөрийн хөрөнгийн хэмжээ бага байсан. Дунджаар тооцохоор ийм үзүүлэлт гарч байсан. Хэдийгээр цэвэр ашиг 140 тэрбум байгаад өөрийн хөрөнгө 16.9%-иар буурч байгаа харагдаж байгаа боловч 15%-иас их байгаа. Үүнийг бид хангалттай гэж үзэж байна.
- Одоо зах зээлд эзлэх байр суурийн талаар танилцуулъя. Өнгөрсөн жил нийт хөрөнгийн хэмжээгээр зах зээлд эзлэх байр суурь 19%-ийг эзэлж байсан байна. Нийт зээлийн 17%, харилцах хадгаламжийн 18%-ийг эзэлж байсан. Нийт зээлийн 17% гэдэг бол өнгөрсөн жилтэй харьцуулахад 1%-иар өссөн үзүүлэлт байна. Баруун талд байгаа зураг бол Голомт банкны зах зээлд эзлэх байр сууриараа нэгдүгээрт явдаг үзүүлэлтүүд байна. Алтны арилжааны 33%, онлайн худалдааны 48%, кастодиан банкаар хийгддэг гүйлгээний хэмжээгээр 52%, орон сууцны зээлийн 24%, кредит картын 41%, аккредитивын хэмжээгээр 77% гэсэн байна. Нийт зээл болон харилцах хадгаламжийн хувь 1%-иар өснө гэдэг бол маш том чухал үзүүлэлт юм. Бид 2023 онд нийт зээлийн энэ хувийг 18-д хүргэнэ гэсэн төлөвлөгөө гаргасан байгаа. Бид Монгол улсын гуравдагч том банк гэдэг байр сууриа хадгална мөн эдийн засгийн 19-20%-ийг бүрдүүлдэг банк байна гэж төлөвлөсөн байгаа. Одоо дэлгэрүүлээд чухал үзүүлэлт рүү оръё. Нийт активын хэмжээ дээр CAGR гэдэг нь нийт жигнэсэн нийлмэл дундаж өсөлт юм. Сүүлийн 4 жил нийт активын CAGR нь 10.2% байна. Өөрийн хөрөнгийн CAGR нь 9.2% болсон байна. Харилцагчаас татсан CAGR 6.9%, нийт зээлийн CAGR 3.8% байсан байна. Өнгөрсөн 4 жилийн хувьд бид зээлийн багцыг хүссэн хэмжээндээ хүртэл өсгөж чадаагүй байгаа. Энэ жилээс эхлээд бид нарт ямар нэгэн хязгаарлалт бол байхгүй, цаашид 18% болгохоор төлөвлөж байна. Үйл ажиллагааны цэвэр ашиг өндөр өсөлтийг үзүүлж үйл ажиллагааны ашиг 32.5%, цэвэр ашиг 21.5% дундаж өссөн. Цэвэр хүүгийн ахиуц 5.9% гарсан. Зардал орлогын харьцаа 41.5-33.3% болж буурсан энэ нь маш сайн үзүүлэлт. Чанаргүй зээлийн харьцаа 6.5% байгаа. ROE хөрөнгө оруулагчдын хувьд маш чухал тоо 2022 онд 19.5% байсан. Бид цаашид ч гэсэн энэ үзүүлэлтийг 15%-иас өндөр 20% орчим байлгана. Ирэх 3-5 жилд ийм байлгана гэдэг төлөвлөгөөтэй байгаа.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа 17.9%, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 35.3% байна. IPO гаргасны дараа манай хувьцааны тоо 808 сая болж өссөн байгаа. Бид Монголбанкнаас тавьж байгаа бүх шаардлага шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаж байгаа.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

2022 оны Монголбанкны тайлангаар



- Банкны гаргасан чухал амжилтуудын талаар танилцуулав:

БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА 2022

ОЛОН УЛСЫН БАНК

- Голомт банк АНУ, Их Британи, ЕХ-ны Оросын банкнуудад тавьсан хориг арга хэмжээг бүрэн дагахын зэрэгцээ МҮЛС-ын стратегийн ач холбогдол бүхий худалдааны төлбөр тооцоог ОХУ-тай хийж гүйцэтгэсэн.
- 53 сая.долларын эх үүсвэрийг гадаадын зээлдэгчдээс татсан

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН СИСТЕМ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- Шинээр "CARDZONE" картны системийг амжилттай хэрэгжүүлсэн;
- Дансны хуулгыг Блокчэйн технологид суурилсан шийдлээр гаргаж эхэлсэн
- Мэдээллийн аюулгүй байдлын стандартыг шинэчилсэн - ISO27001, PCI-DSS, GDPR (эдгээр 3 стандартыг хангасан цорын ганц банк)
- Кибер аюулгүй байдлын үйл ажиллагааны төвийг шинэчилсэн
- ХХБ-тай хамтран ажиллаж АТМ/СДМ-ын шимтгэлийг бууруулсан.



ХҮНИЙ НӨӨЦ

- "Ажилтан төвтэй банк" стратегийг амжилттай хэрэгжүүлсэн
- "Great place to work" батламжийг Монгол Улсын банк, санхүүгийн салбарт анхлан авлаа



- Тогтвортой санхүүжилтийн хэрэгжилтүүд. Монгол улсад зөвхөн Голомт банк гэлтгүй бүх банкнууд тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагааг сайжруулах талд хүчин чармайлт гаргаж ажилладаг. Монголбанк болон тогтвортой санхүүжилтийн холбооноос манай банкныг 2022 оны онцлох Тос байгууллагаар тодруулсан байгаа. Мөн өнгөрсөн онд Монголбанк олон улсын санхүүгийн корпорацтай хамтарч Тос-ийн хэрэгжилтийн үнэлгээг хийсэн. Үнэлгээ хийсэн банкнуудаас Голомт банк ганцаараа А+ үнэлгээг авсан бусад банкнууд А үнэлгээг авсан. Бүх банкнууд ногоон зээл, ногоон бүтээгдэхүүн гаргаж байгаа. Яагаад Голомт банк А+ үнэлгээг авсан бэ гэвэл миний харж байгаагаар Голомт банк зээлийн багцынхаа хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжээг шинжлэх ухааны аргачлалаар тооцож эхэлсэн байгаа. Энэ хүчин чармайлт үзүүлэлтээрээ бусад банкнаас урд алхаж байна хэмээн үнэлсэн. Процессын удирдлага хувьд тасралтгүй сайжруулдаг. 2022 онд бид robotic process automation хэрэгжүүлж байгаа.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА 2022

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН ХЭРЭГЖИЛТҮҮД

- Монгол банк болон ТоС Холбооноос 2022 оны "Онцлох ТоС байгууллага"-аар тодрууллаа.
- Монголбанк, Олон улсын Санхүүгийн корпорацтай хамтран гүйцэтгэсэн ТоС-ийн хэрэгжилтийн үнэлгээгээр Голомт Банк А+ үнэлгээ аван ТоС-ийн хэрэгжилтийн үр дүнг ахиулав.

ПРОЦЕССЫН УДИРДЛАГА

- RPA (Robotic Process Automation) хэрэгжүүлэв - 21 гол процессыг автоматжуулж, жилд 13,069 хүн цаг хэмнэсэн
- Өр цуглуулах процессыг шинэчилж сайжруулав - Хэрэглээний зээлийн PDL-ийг 2.0%-с 1.0% болгон бууруулсан
- Зээлийн хэрэг бүртгэл, хяналтын үйл ажиллагааг сайжруулж шинэчлэв
- Иргэдийн зээлийн процесс автоматжуулах төсөл: Зээл олгох үйл явцыг хурдасгахын тулд зээлийн хүсэлтийг K2 системд нэгтгэн автоматжуулсан

БУСАД ГОЛ АМЖИЛТУУД

- Монгол Банкнаас (PWC-тэй хамтран) хийсэн Активын чанарын үнэлгээг (AQR) амжилттай хийсэн
- Банкны IPO-г амжилттай хэрэгжүүлж, 118.8 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн
- Голомт банк нь Банкны тухай хуулийн дагуу нээлттэй хувьцаат компани болсон

- 2023 оны бизнес төлөвлөгөөний талаар танилцуулав:

БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ – Гол чиглэлүүд 2023

НИЙТ ЗЭЭЛ – 4,514 тэрбум төгрөг хүргэх, 617 тб /+16%/ өсөлт

- Зээлийн чанар, ашигт ажиллагаанд анхаарах. Зах зээлд эзлэх хувийг 17.3%-с 18.4% болгож нэмэгдүүлэх.

ХАРИЛЦАГЧИЙН ЭХ ҮҮСВЭР – 6,207 тэрбум төгрөг хүргэх, 463 тб /+8%/ өсөлт

- Хямд өртөгт эх үүсвэрт төвлөрөх. Зах зээлд эзлэх хувийг 18.4%-с 19.3% болгож нэмэгдүүлэх.

ЭХ ҮҮСВЭР ТАТАХ – Нийт 90 сая Ам.долларын гаднын эх үүсвэр татах

- Гадаад, дотоодын урт хугацаат эх үүсвэрийг хямд өртгөөр үргэлжлүүлэн татах

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- "Нээлтэй банк" стратегийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэх

ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- Алдаагүй банк. Шилдэг харилцагчийн туршлага; Голомтын туршлага.

БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ – Гол өөрчлөлтүүд, дижитал шилжилт 2023

БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ:

- Банкны үйлчилгээг илүү сайжруулах зорилгоор "Байгууллага хөгжлийн газар"-ыг байгуулав.
- Урт хугацаат гаднын эх үүсвэрт төвлөрөх, тогтвортой санхүүжилт болон худалдааны санхүүжилтийг дэмжих зорилгоор "Олон улсын банкны газар"-ыг байгуулав.

ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ:

- Бүрэн дижитал цалингийн зээл 2.0
- Social Pay 3.0
- Гар утсанд суурилсан ПОС
- Alipay, Wechat төлбөр хүлээн авах боломж
- Дотоод дижитал шилжилтийг үргэлжлүүлэх






ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ – Зорилтууд

САНХҮҮГИЙН ЗОРИЛТУУД 2023



ТАТВАРЫН ДАРААХ АШИГ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ (ROE) 2023-2026



- Санхүүгийн гүйцэтгэл 2023 оны эхний улирлаар зорьсон төлөвлөгөөндөө хүрсэн илүү өндөр үзүүлэлттэй ажиллаж байна. Монгол банкны аргачлалаар гаргасан аудитлагдаагүй тоо байна. Нийт зээлийн хувьд бид төлөвлөгөөндөө арай хүрээгүй харин харилцагчийн эх үүсвэр, үйл ажиллагааны ашиг, татварын дараах ашиг төлөвлөгөөнөөсөө давсан үзүүлэлттэй байгаа. Өмнө нь бид проспектууд заахдаа ногдол ашгийг 7 тэрбум төгрөгөөр тооцож байсан хэдий ч бид 2022 онд маш сайн үзүүлэлттэй ажиллаж 40 тэрбум төгрөгийг ногдол ашигт тараахаар болсон. Хөндлөнгийн аудитаар баталгаажсан тайлангийн дараа манай цэвэр ашиг 116 тэрбум төгрөг гэж гарсан. Ногдол ашгийн дүн аудитлагдсан дүнтэй харьцуулахад 35% болж байгаа. Голомт банкны ногдол ашгийн бодлого бол Монгол банкны стандарт журмын дагуу нийт цэвэр ашгийн 40 хувь байх бодлоготой. Бид тус бодлогыг цаашид тогтвортой хэрэгжүүлэхээр ажиллана.

САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ 2023

САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ БОЛОН ЗОРИЛТ – 2023 Q1

	Зорилт	Гүйцэтгэл	Төрөл	%
Нийт зээл	3,960	3,911	(50)	-1%
Харилцагчийн эх үүсвэр	5,725	5,800	74	1%
Үйл ажиллагааны ашиг	70	88	18	26%
Татварын дараах ашиг	26	34	7	28%

- Зээл:** 50 тэрбум төгрөг, 1% зорилтоос бага
- Харилцагчийн эх үүсвэр:** 74 тэрбум төгрөг, 1% зорилтоос их
- Цэвэр ашиг:** 7 тэрбум төгрөг /28%/ зорилтоос их

НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО



- ТУЗ-ийн шийдвэрээр нэгж энгийн хувьцаанд 50 төгрөг олгохоор (нийт 40.0 тэрбум төгрөг) шийдвэрлэсэн, энэ нь МБ-ны стандартад суурилсан цэвэр ашгийн 40 хувь юм.
- СТОУС-ын дагуу аудитлагдсан санхүүгийн тайлангаар 2022 оны цэвэр ашиг 116.5 тэр буюу МБ-ны стандартын дагуу цэвэр ашгаас (100 тб.төг) 16 тб.төг буюу 16%-р их гарсан тул ногдол ашиг, цэвэр ашгийн харьцаа 35% болж өөрчлөгдсөн
- Банкны ногдол ашгийн бодлого: Монгол банкны стандартын дагуу хилийн цэвэр ашгийн 40% орчим хувийг ногдол ашгаар тараана.

Гүйцэтгэх захирал Норихико Като: Эхний улирлын үр дүнд үндэслэн, 2023 оны төлөвлөгөө болох 140 тэрбум төгрөгийн цэвэр ашигт хүрнэ гэдэгтэй итгэлтэй байна. Мэдээж макро эдийн засаг болон эдийн засгийн тогтворгүй байдал бидэнд сөргөөр нөлөөлөх зүйлүүд байгаа. Гэхдээ бид хөрөнгө оруулагчдын итгэлийг алдахгүйн төлөө 2023 оны зорьсон төлөвлөгөөндөө хүрэхээр өдөр бүр хичээл зүтгэл гарган ажиллах болно. Баярлалаа.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Хурлын дарга Г.Ганболд: Като захиралдаа баярлалаа. Като захирал Монгол улсад банкны зах зээлд нийт 10 гаруй жил ажиллаж байна. Хаан банканд төслийн удирдагч, Гүйцэтгэх захирлын албан тушаал хашиж байсан. Голомт банкны Гүйцэтгэх захирлаар 4 дэх жилдээ ажиллаж байгаа олон улсын туршлагатай банкир хүн. Өнөөдрийн хурлын хамгийн гол зүйл бол бид хийсэн ажил тайлангаа та бүхэнд тайлагнах ёстой, засаглалын зарчмаар бид нээлттэй институт. Та бүхний хөрөнгө оруулсан, мөнгөө хийсэн байгууллага яаж ажилласан, үйл ажиллагаа санхүүгийн хувьд ямар байсан, олон улсын түвшинд ямар байсан, инновац бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хувьд ямар байсан тайлангаа тавих ёстой. Менежментийн зорилго бол аль болох сайн мэдээ дуулгах ёстой. Като захирлын илтгэлээр дамжуулаад бид сайн мэдээ дуулгасан байх гэж найдаж байна. Банк бол нэлээн өндөр зохицуулалттай байгууллага, олон нийтээс хөрөнгө татаж ажилладаг, бид 9 их наядын банк, өндөр хяналттай өндөр тайлагналтай явдаг. Асуулт байгаа байх. Хурлын даргын зүгээс ямар саналтай байна гэхээр одоо ТУЗ-ийн дүгнэлт явна, үүний дараа аудитын тайлангийн талаар хөндлөнгийн дүгнэлт өгнө, энэ 2 тайланг сонсоод дараа нь заалнаас асуулт авъя. Дараагийн асуудал бол ТУЗ-ийн дүгнэлтийг ТУЗ-ийн гишүүн Мөнхтөр захирал танилцуулна.

Хэлэлцэх асуудал 2. Голомт банк ХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн гишүүн Д.Мөнхтөр: Голомт банкны эрхэм хувьцаа эзэмшигчид болон энэ хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Голомт банкны ТУЗ бол Монгол улсын компанийн тухай хууль, банкны тухай хууль болон засаглалын зарчмуудын хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа. ТУЗ өөрийн эрх үүргийн хүрээнд Голомт банкны стратеги болон бизнес төлөвлөгөөг батлан ажилласан. 2022 оны стратеги төлөвлөгөө болон үйл ажиллагааны төсвийг 2022 оны 1 сарын 18-ны өдрийн 01 тоот тогтоолоор батлан, хэрэгжүүлж ажиллах үүргийг Гүйцэтгэх удирдлагад хүргэж ажилласан. Банкны үндсэн бизнес төлөвлөгөөнөөс гадна банкны бизнесийн чиглэл тус бүрээр бизнес төлөвлөгөөг баталж өгсөн. Бизнесийг дэмжих нэгжүүдийн төлөвлөгөөг мөн батлан ажилласан. Эдгээр бодлого бизнесийн төлөвлөгөөний хэрэгжилттэй ТУЗ-ийн улирал бүрийн хурал, сар бүрийн аудитын хорооны хурлаар танилцаж хянаж ажилласан. ЭУГ бодлого эрсдэлийн лимитийг батлан үүрэг эрх өгч ажилласан.



СТРАТЕГИ ЗОРИЛГО

2022 оны Голомт банкны стратеги төлөвлөгөө

• Голомт банкны 2022 оны стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны төсвийг 2022 оны 01 сарын 18-ны өдөр 00/01 тоот Тогтоолоор батлан Гүйцэтгэх удирдлагад хэрэгжүүлэх үүргийг өгсөн.

Бизнес төлөвлөгөө

1. Корпорэйт бизнес төлөвлөгөө /Corporate BP/
2. Жижиг дунд бизнесийн бизнес төлөвлөгөө /SME BP/
3. Иргэдийн бизнесийн бизнес төлөвлөгөө /Retail BP/
4. Дижитал банкны бизнес төлөвлөгөө /Digital BP/
5. Арилжааны бизнес төлөвлөгөө /Trading BP/
6. Гадаад худалдааны санхүүжилтийн бизнес төлөвлөгөө /Trade finance BP/
7. Гадаад эх үүсвэрийн бизнес төлөвлөгөө /Foreign funding BP/
8. Даатгалын зуучлалын бизнес төлөвлөгөө /Bancassurance BP/
9. Кастодианы бизнес төлөвлөгөө /Custodian BP/
10. Тусгай активын бизнес төлөвлөгөө /SAD BP/

Бодлого болон ажлын төлөвлөгөө/action plan

1. Актив, Пассивын удирдлагын бодлого /ALM policy/
2. Харилцагч төвтэй банкны бодлого /Customer centric banking policy/
3. Бизнес процесс менежментийн бодлого /BPM policy/
4. Хүний нөөцийн бодлого /HR policy/
5. Маркетингийн бодлого /Marketing policy/
6. Мэдээлэл технологийн бодлого /IT policy/

Аудитын хороогоор **сар бүр** Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар **улирал бүр** Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл, төсвийн зарцуулалтыг хянадаг.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО – ЭРСДЭЛИЙН ЛИМИТ


2022 оны Голомт банкны эрсдэлийн удирдлагын бодлого

- Голомт банкны 2022 оны стратеги төлөвлөгөөтэй уялдсан Эрсдэлийн бодлогыг тодорхойлж, хязгаарлагдах эрсдэлийн лимитүүдийг ТУЗ-өөс 2021.12.23 өдрийн 00/32-1 тоот Тогтоолоор баталсан.
- Эрсдэлийн лимитүүдийг:
 - Зээлийн төвлөрлийн эрсдэлүүд
 - Зээлийн багцад эзлэх эдий засгийн салбарын төвлөрөл
 - Зээлийн чанарын үзүүлэлт
 - Зах зээлийн эрсдэл
 - Хөрвөх чадварын эрсдэл
 - Өөрийн хөрөнгийн хүрэлцээ
 - Үйл ажиллагааны эрсдэл зэргийг хамарсан **нийт 20 эрсдэлийн лимитийг тогтоож**

эдгээр эрсдэлийн хязгаарлалт хэмжүүрүүдийн хэрэгжилтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Эрсдэлийн удирдлагын хороогоор **тогтмол хянаж** ажилсан.

БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ - АКТИВ

Балансын гол үзүүлэлтүүд (тэрбум ₮)



2022 оны бизнесийн үйл ажиллагааны үр дүнд балансын бүх гол зүйлүүд өссөн (жишээ нь Эх үүсвэрийн аян гэх мэт).


Харилцагчийн эх үүсвэрийн бүтэц



Тэнцвэртэй, төрөлжүүлсэн харилцагчийн эх үүсвэрийн бүтэц

БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ - ЗЭЭЛ

Нийт зээл (тэрбум ₮)



ҮЦ-ны танилцуулга

Нийт зээлийн бүтэц



Тэнцвэртэй, төрөлжүүлсэн нийт зээлийн багц

- ҮЦ-ны танилцуулгад тусгасны дагуу нийт зээлийн багцыг 397 тэрбум төгрөгөөр /11.3%/ нэмэгдүүлсэн
- Чанаргүй зээлийн хувь 6.5% буюу ҮЦ-ны танилцуулгад тусгасан 6.7%-иас сайн үзүүлэлттэй
- Нийт 20.1 тэрбум төгрөгийн буюу 2,055 харилцагчийн 2,444 зээлийг эрсдэлийн сангаас хаав (2022.03.24 болон 2022.06.24-ний өдрийн ТУЗ-ийн тогтоолын дагуу)
- Тэнцвэртэй, төрөлжүүлсэн зээлийн багцын бүтцийг хадгалж ажиллав




ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ



АШИГТ АЖИЛЛАГАА

Түүхэн өндөр ашиг - зорилтоос давсан

Ашигт ажиллагаа (тэрбум ₮)



ТУЗ-ийн гишүүн Д.Мөнхтөр: Эдгээр бүх санхүүгийн үр дүн болоод үйл ажиллагааны үр дүн мөн хөндлөнгийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг үндэслэн ТУЗ-өөс Голомт банкны 2022 оны тавьсан зорилго зорилтууддаа амжилттай сайн биелүүлж ажилласан гэж дүгнэсэн болно. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Хурлын дарга Г.Ганболд: Тус дүгнэлттэй холбогдуулаад шийдвэр гарах ёстой. Энэ өмнө нь та бүхэнд хүргэгдсэн байгаа. Өнөөдрийн хурлаараа бид баталгаажуулах ёстой байгаа.

Тогтоолын төсөл

Банкны 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.7 дахь заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Голомт банкны дүрмийн 8.2.8 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 сарын 26-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Голомт банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүн, түүнийг баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.

Тус шийдвэрээс асуух зүйл байна уу? Асуулт байхгүй бол хөндлөнгийн аудитын тайлан дүгнэлтийг PwC Mongolia байгууллагын Удирдах партнес Шаукат та бүхэнд танилцуулна.

Хэлэлцэх асуудал 3. 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулав.

Танилцуулсан нь:

PwC Mongolia, Удирдах партнер Шаукат Тапиа: Сайн байна уу, намайг Шаукат Тапиа гэдэг би PwC Mongolia удирдах партнер. Өнөөдөр надтай хамт ахлах аудитор Энхзул оролцож байна. Zoom-р Аудитын багийн ахлах партнер Айгул Ахметова оролцож байгаа. Бидэнд өнөөдөр илтгэх тавих боломж олгосонд баярлалаа.

Аудитын багийн гишүүдийг танилцуулав:



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Аудитын багийн гишүүд

Аудитын багийн Ахлах Партнер	Удирдах Партнер	Чанарын Хяналтын Партнер	Татварын Захирал	Ахлах Менежер
 Айгуль Ахметова Партнер Санхүүгийн Үйлчилгээний салбар хариуцсан Партнер	 Шаикат Таниа Удирдах Партнер	 Гордон Латимир Санхүүгийн Үйлчилгээний Аудитын Партнер, ЧХП	 Чойжамцын Цэндмаа Татварын захирал	 Мөнхжаргалын Баасанжаргал Аудитын Ахлах Менежер
Эрсдэл Баталгаажуулалтын Үйлчилгээний Ахлах Менежер	Эрсдэл Баталгаажуулалтын Үйлчилгээний Ахлах Ажилтан	Ахлах Ажилтан	Туршлагатай Ажилтан	Туршлагатай Ажилтан
 Ассем Кинзибаева ЭБҮ-ий Ахлах Менежер	 Ганболдын Халиун Ахлах Ажилтан	 Бат-Эрдэнийн Энхзул Аудиторын Ахлах	 Ёндонжийн Амула Аудиторын Туслах	 Мижиддоржийн Цэнд-Аюуш Аудиторын Туслах

PwC Mongolia, Удирдах партнер Шаикат Таниа: Хараат бус байдлын мэдэгдлийг танилцуулав. 3 сарын 30-ны өдөр бид аудитын дүгнэлтээ гаргасан. Бидний аудит бол аудитын дүгнэлтэд хязгаарлалтгүй буюу зөрчилгүй гэсэн дүгнэлт гаргасан. Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу гүйцэтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгээд дүгнэлтээ гаргасан байгаа. Бид олон улсын аудитын стандартыг дагаж мөрдөж ажилласан. Мөн аудитын стандартын дагуу дэлгэрэнгүй аудитын тайлан гаргасан байгаа. Стандартын дагуу бид тайланд аудитын гол асуудлыг тусгасан байгаа. Үүнд зээл ба хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын талаар тусгасан байгаа. Эдгээрийг үнэлэхэд шаардлагатай бүх ажлыг хийж гүйцэтгэсэн. НБОУС-ын зүгээс гаргасан ёс зүйн дүрмийг дагаж мөрдөн ажилласан. Голомт банкнаас хараат бусаар ажилласан байгаа. Бидэнтэй хамтарч ажилласан ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад баярлалаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Аудитын үр дүн

Аудитын дүгнэлт

Гүйцэтгэсэн аудитын ажлыг үндэслэн бид хязгаарлалтгүй/зөрчилгүй дүгнэлтийг гаргасан бөгөөд энэ нь санхүүгийн тайлангийн аудиторын тайланд тусгагдсан болно.

Бид хөрөнгийн биржид бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагад тавигдах шаардлагын хүрээнд дэлгэрэнгүй аудитын тайланг гаргасан бөгөөд энэ тайланд харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны хүлээгдэж буй эрсдэлийн алдагдалын талаар тайлбарласан аудитын гол асуудлууд (КАМ) багтсан болно. Аудитын гол асуудалд тусгагдсан асуудлыг үнэлэхэд шаардлагатай бүх ажлуудыг бид хийж гүйцэтгэсэн.

Аудитын тайлангаас авсан ишлэл:

Хараат бус Аудиторын Тайлан

Голомт Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, Голомт Банк ХК ("Банк" гэх)-ийн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал хийгээд мөн тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бодитойгоор илэрхийлсэн байна.

Хурлын дарга Г.Ганболд: Баярлалаа. Энэ хөндлөнгийн хараат бус дүгнэлт бол ТУЗ дээр илүү дэлгэрэнгүй байдлаар танилцуулагдсан байгаа. Ингээд Голомт банкны 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой тайлан, тайланд хийсэн дүгнэлтүүдийг та бүхэнд танилцууллаа. Хуралд манай ТУЗ-ийн бусад гишүүд, мөн нэлээд хэмжээний хувьцаа эзэмшигчид онлайнаар оролцож байгаа. Та бүхэн асуулт асуух бүрэн нээлттэй байгаа. 2022 оны хувьд Голомт Банк IPO хийхдээ үнэт цаасны танилцуулга тараасан. Тэр танилцуулга дээр тавьсан зорилт та бүхэнд амласан амлалтууд бүгд биелсэн. Нийт 9 их наядын активтай, 2,000 орчим ажилчидтай, 100 гаруй салбар тооцооны төв, касс орон даяар ажиллаж байна, 1 сая орчим харилцагчидтай, 20,000 орчим хувьцаа эзэмшигчидтэй институт.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Бид нээлттэй ХК болсноос хойш бидний гол зорилго бол хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг аль болох тогтвортой байлгах зорилттой байсан. Одоо та бүхнээс нээлттэй асуулт авъя. 10-15 минутын хугацааг тавьсан байгаа. Асуулт одоогоор байхгүй байх шиг байна. Дараагийн шийдвэрийг та бүхэнд танилцуулъя. Ногдол ашгийн тогтоол байгаа.

Хэлэлцэх асуудал 4. 2022 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулав.

Ногдол ашгийн тогтоол

Хурлын дарга Г.Ганболд: Энэ шийдвэр өмнө нь та бүхэнд хүрсэн байгаа. Энэ тушаал хэрэгжсэн. 4 сарын 18-ны өдрөөс ногдол ашиг хуваарилагдаж орсон. Нэгж хувьцаанд 50 төгрөгийн ногдол ашиг нийт 40 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилсан байгаа. Нийт масс эхний 2 өдөртөө багтаж орсон, 20,000 орчим хувьцаа эзэмшигчид байгаа учир хэд хонож орсон байгаа байх. Одоо хэлэлцэх асуудлын дарааллаар ТУЗ-ийн ажлын тайлан, 2023 оны төсвийг та бүхэнд танилцуулна.

Санхүүгийн Зохицуулах Хорооны "Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай" тогтоолын 1-д заасны дагуу Хувьцаат компани нь зөвхөн эрх бүхий зуучлагч байгууллага болох "ҮЦТХТ" ХХК-аар дамжуулан ногдол ашиг хуваарилах гэрээний үндсэн дээр тараана.

ТУЗ-ийн шийдвэр гаргасан огноо:

2023.02.15

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр:

2023.04.04 /Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр/

Нэгж хувьцаанд олгох ногдол ашиг:

50 төгрөг

Нийт олгох ногдол ашгийн хэмжээ:

40,432,865,300 төгрөг

Зохицуулагч байгууллагаас ногдол ашиг тараах зөвшөөрөл олгосон хугацаа:

2023 оны 3 сарын 22-ны өдөр

ҮЦТХТ-тэй ногдол ашиг тараалгах гэрээ байгуулсан хугацаа:

2023 оны 4 сарын 18-ны өдөр

Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсан хугацаа:

2023 оны 4 сарын 20-ны өдөр

Голомт банк ХК, ногдол ашгийн мэдээлэл

5. 2022 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ажлын тайлан, 2023 оны төсвийг танилцуулж батлах.

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга З.Солонго: Сайн байцгаана уу, миний бие З.Солонго ТУЗ-ийн нарийн бичгийн дарга байна. ТУЗ-ийн 2022 оны ажлын тайлан болон 2023 оны цалингийн төсвийг батлуулахаар саналыг танилцуулна.

- Голомт банкны засаглалын бүтцийг танилцуулав:





ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

- ТУЗ-ийн хурал, баталсан тогтоолын талаар танилцуулав:

2022 онд Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь:

- 4 ээлжит
- 8 ээлжит бус хурал хуралдуулж (нийт 12)
- 61 асуудал хэлэлцэж
- 34 Тогтоол шийдвэр гаргасан байна.

Шийдвэрүүдийг ангилж үзвэл

Стратеги, хөрөнгө оруулалттай холбоотой:

- нийт ТУЗ-ийн хурал, Хороодын хурлаар 20 гаруй хэлэлцүүлэг болсны үндсэн дээр 9 шийдвэр гаргасан байна. /Баримтлах стратеги, бизнес төлөвлөгөө, төсөв багтана/

Дотоод үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт сайжруулах:

- нийт 17 шийдвэр гаргаж хэрэгжилтийг хянан ажиллаж байна.

Бодлогын баримт бичиг, дүрэм журам, засаглалыг сайжруулах:

- нийт 10 бодлого журмыг сайжруулан шинэчилсэн байна.

- Аудитын Хорооны тайланг танилцуулав:

Бүтэц бүрэлдэхүүн:

- Хорооны Дарга ТУЗ-ийн Хараат бус гишүүн Жэймс Б. Дваер
- 5 гишүүний дийлэнх буюу 3н гишүүн ТУЗ-ийн Хараат бус гишүүн.

Хорооны хурал:

- 2022 онд нийт 9 удаа дундаж ирц 93%-тай хуралдсан
- нийт 52 асуудал хэлэлцэж холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан



- Эрсдэлийн удирдлагын хорооны тайланг танилцуулав:

Бүтэц бүрэлдэхүүн:

- Хорооны Дарга ТУЗ-ийн Хараат бус гишүүн Жэймс Б. Дваер
- 5 гишүүний дийлэнх буюу 3н гишүүн ТУЗ-ийн Хараат бус гишүүн.

Хорооны хурал:

- 2022 онд нийт 27 удаа буюу дунджаар сард 2 удаа хуралддаг
- нийт 97 асуудал хэлэлцэж холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан

Хэлэлцсэн асуудал:

- 50% нь 20 тэрбум төгрөг буюу түүнээс зээлтэй групп компаниудын хүсэлтийг шийдвэрлэсэн Зээлийн хорооны хяналт
- 35% нь Эрсдэлийн тайлан мэдээлэл, эрсдэлийн удирдлага бодлого
- 15% нь бусад цаг үеийн асуудал, мэдээлэл



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

- Засаглалын хорооны тайланг танилцуулав:

Хорооны чиг үүрэг:

- Засаглал, Ёс зүй, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх үйл ажиллагаа

Бүтэц бүрэлдэхүүн:

- Хорооны Дарга ТУЗ-ийн Дарга
- 3 гишүүний 1 гишүүн ТУЗ-ийн Хараат бус гишүүн, 1 Гишүүн Засаглалын мэргэжилтэн

Хорооны хурал:

- 2022 онд нийт 5 удаа хуралдсан
- нийт 15 асуудал хэлэлцэж холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан

Хэлэлцсэн асуудал:

- 50% нь 20 тэрбум төгрөг буюу түүнээс зээлтэй групп компаниудын хүсэлтийг шийдвэрлэсэн Зээлийн хорооны хяналт
- 35% нь Эрсдэлийн тайлан мэдээлэл, эрсдэлийн удирдлага бодлого
- 15% нь бусад цаг үеийн асуудал, мэдээлэл

ТУЗ 2022 онд нийт 53 удаа хуралдсан буюу 7 хоног бүр хуралдсан үзүүлэлттэй байна. 2023 оны ТУЗ-ийн төсөв 1,192 сая төгрөг байна. Үүнийг балуулахаар танилцуулж байна.

Задаргаа:

	Жилд			
	Олгох цалин	НДШ 11.5%	ХХОАТ	НДШ байгууллага 12.5%
Жилийн төсөв /төсөөлөл/	913,462,733	36,366,000	147,464,123	94,386,654

Хурлын дарга Г.Ганболд: Манай ТУЗ нийт 9 гишүүнтэй үүнээс 5 гишүүн ердийн, 4 гишүүн хараат бус байна. Өнөөдрийн батлах асуудал бол 2023 оны төсөв байгаа. Та бүхэнд шийдвэрийг уншиж танилцуулъя.

Тогтоолын төсөл

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсөв батлах тухай

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дахь заалт, Голомт банкны дүрмийн 8.2.12 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 сарын 26-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Голомт банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсвийг хавсралтаар баталсугай.

Хэлэлцэх асуудал 6. Голомт банкны ТУЗ-ийн гишүүдийг сонгох.

Аудит хариуцсан захирал А.Одонбаатар: Энэхүү танхимд хүрэлцэн ирсэн та бүхэнд болон онлайнаар оролцож байгаа хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэнд хүргэе. Миний бие ирэх 2 жилд Голомт банкны удирдан чиглүүлэх, стратегийн шийдвэр гаргах, засаглалын чухал нэгж болох ТУЗ-ийн сонгуульд нэр дэшигчдийг танилцуулна. Энэ удаагийн сонгуульд 5 ердийн гишүүд, 4 хараат бус гишүүд нэр дэвшиж байна.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Танилцуулсан нь:

1. Ердийн гишүүнд нэр дэвшигчид:

Ч.МӨНХЦЭЦЭГ

Боловсрол:

- Зөвлөлтийн 3-р дунд сургууль, (1978-1988)
- Политехникийн ИС, УУЦМеханик инженер, (1988-1993)
- АНУ-ын Жонс Хопкинсийн ИС, Бизнесийн Удирдлагын магистр, (1999-2001)
- АНУ-ын Харвардын ИС, Удирдлагын манлайллын хөтөлбөр, (2015)
- Англи улсын Оксфордын ИС, Удирдлагын хөгжлийн хөтөлбөр, (2016)

Ажлын туршлага:

- Монголын Хөрөнгийн бирж, Гадаад харилцааны албаны дарга, (1996-1998)
- Дэлхийн банк, Төслийн ко-ординатор, (2004)
- Азийн сан, Төслийн стратеги, хөгжлийн хэлтсийн дарга, (2004-2007)
- Нэпко хэвлэлийн компани, Гүйцэтгэх захирал, (2007-2010)
- Тойм сэтгүүл, Эрхлэгч, Үүсгэн байгуулагч, (2010-2012)
- УБ дах ОУ-ын сургууль, ТУЗ-ийн гишүүн, (2004-2014)
- Монгол Масс Медиа ХХК, ТУЗ-ийн гишүүн, (2014-2018)
- Голомт банк, ТУЗ-ийн ердийн гишүүн, дарга (2012 - одоог хүртэл)

Ж.ҮНЭНБАТ:

Боловсрол:

- Нийслэлийн 30-р болон 14-р дунд сургууль, (1970-1980)
- ЗХУ-ын Москва хотын эдийн засаг статистикийн ДС, Эдийн засагч, статистикч, (1980-1985)
- АНУ-ын Колумбын их сургууль, Олон улсын харилцааны мастер (1993-1994)

Ажлын туршлага:

- Монгол банк, Мэргэжилтэн, Газрын дарга, (1990-1996)
- Монгол банк, Ерөнхийлөгч (1996-2000)
- Азийн хөгжлийн банк, МУ-ыг хариуцсан Захирагч, (1998-1999)
- Дэлхийн банк, МУ-ыг хариуцсан Захирагч, (1998-1999)
- Монголын банкны холбоо ТББ, Гүйцэтгэх захирал, (2000-2006, 2015-2020)
- Монгол банк, Хяналтын зөвлөлийн гишүүн, (2004-2016)
- Монголын Уул уурхайн корпорац, ТУЗ-ийн хараат бус гишүүн, (2010–одоог хүртэл)
- АПУ ХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн, (2015 – одоог хүртэл)
- Нээлттэй нийгэм форум ТББ, Удирдах зөвлөлийн гишүүн, (2016 – одоог хүртэл)
- Голомт банк, ТУЗ-ийн хараат бус гишүүн, (2011-2019)
- Голомт банк, ТУЗ-ийн ердийн гишүүн, (2020 – одоог хүртэл)

О.ГАНЖОЛОО

Боловсрол:

- Монгол-Оросын хамтарсан 2-р дунд сургууль, (1984-1994)
- МУИС, Банк, Санхүү, (1994-1997)
- ХБНГУ-ын Чөлөөт ИС, Бизнесийн Удирдлагын магистр, (1997-2002)
- ХБНГУ-ын Чөлөөт ИС, Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, (2006-2008)
- Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч

Ажлын туршлага:

- Голомт банк, Санхүүгийн хяналтын газар, мэргэжилтэн, (2003)
- Бодь групп ХХК, ХБНГУ дах Төлөөлөгчийн газар, ажилтан, (2004-2005)



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

- ПрайсУотерХаус Куперс Аудит ХХК, ХБНГУ, Зөвлөх, (2008-2010)
- ПрайсУотерХаус Куперс Аудит ХХК, Монгол Улс, Ахлах зөвлөх, (2010-2011)
- Бодь интернэшнл ХХК, Санхүү хариуцсан захирал, (2011-2018)
- Голомт санхүүгийн нэгдэл ХХК, Гүйцэтгэх захирал, (2016-одоог хүртэл)
- Голомт банкны ТУЗ-ийн ердийн гишүүн (2022-одоог хүртэл)

Д.МӨНХТӨР

Боловсрол:

- Завхан аймгийн 3-р дунд сургууль, (1983-1993)
- МУИС, Банк, Санхүү, Бакалавр, (1993-1997)
- АНУ-ын Оклахомагийн ИС, Бизнесийн Удирдлагын магистр, (2007-2009)

Ажлын туршлага:

- Голомт банк, Эдийн засагч, (1997-1999)
- Голомт банк, Зээлийн газрын захирал, (1999-2007)
- Голомт банк, Бүртгэл тооцооны газрын захирал, (2009-2011)
- Голомт банк, Үйл ажиллагаа хариуцсан тэргүүн дэд захирал, (2011-2014)
- Бодь Интернэшнл ХХК, Дэд захирал, Төслийн удирдагч, (2014-2019)
- Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК, Гүйцэтгэх захирал, (2019-одоог хүртэл)
- Голомт банк, ТУЗ-ийн ердийн гишүүн, (2012-одоог хүртэл)

УРС Э.ШВАРЦЕНБАХ

Боловсрол:

- Швейцари улсын Цюрихын худалдааны коллеж (1966-1968)
- Канад улсын Гэгээн Франсис Хавиэрын Их сургуулийн Хуулийн сургуулийн -Хүндэт доктор (2000)

Ажлын туршлага:

- Швейцарийн холбооны банк, Гадаад арилжааны хэлтэс (1968-1973)
- Швейцар Улс, Бүс нутаг дахь Монгол улсын өргөмжит Консул (2010-одоог хүртэл)
- Швейцар Улсын 5 од бүхий тансаг зэрэглэлийн Dolder Grand зочид буудлын эзэмшигч
- Үл хөдлөх хөрөнгийн болон Санхүүгийн компанийг үүсгэн байгуулж, амжилттай удирдаж байна.
- Голомт банк, ТУЗ-ийн ердийн гишүүн, (2011-одоог хүртэл)

Хараат бус гишүүнд нэр дэвшигчид:

АНТОНИО Л.АБЕЛЛО

Боловсрол:

- Испани улсын Барселонагийн ИС, Хуулийн чиглэлээр бакалавр
- Испани улсын IESE бизнесийн сургууль, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага:

- Paribas банк, Хувьцаа руу чиглэсэн хөрөнгийн зах зээлийн банкир
- Goldman Sachs банк, Деривативийн банкир
- Credit Suisse банкны Сингапур дахь салбар, Тогтмол орлогын бүтцийн группын захирал
- Turms Advisors, Нөхөрлөлийн гишүүн, Захирал (2009-одоог хүртэл)
- Голомт банк, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2014-одоог хүртэл)

ЖЭЙМС Б.ДВАЙЕР

Боловсрол:

- АНУ-ын Нотр Дамын ИС, Бизнесийн удирдлагын бакалавр (1961-1965)
- АНУ-ын Колумбын ИС-ийн Бизнесийн сургууль, Бизнесийн удирдлагын магистр (1968-1970)

Ажлын туршлага:

- UBS банк, Компанийн нэгдэл, компани худалдан авах процесс хариуцсан захирал (1970-1984)



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

- Компанийн хөгжлийн холбоо, Ерөнхийлөгч (1984-1985)
- KPMG Зөвлөх үйлчилгээ, Хөрөнгө оруулалтын банкны зөвлөх (2001-2003)
- Хойд Америк-Монголын бизнес зөвлөл, Үйл ажиллагаа хариуцсан захирал (2003-2007)
- Монголын урлагийн зөвлөл, Дэд тэргүүн (2007-2011)
- Жиант Степпес оф Жазз, Дэд тэргүүн (2006-2012)
- Эдийн засаг, бизнесээр мэргэшиж буй оюутнуудын олон улсын холбооны Монгол дахь зөвлөл, ТУЗ-ийн дэд дарга (2009-2012)
- Монголын хөгжлийн нөөц ХК, ТУЗ-ийн гишүүн (2010-2014)
- Монголын бизнесийн зөвлөлийн Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн дэд дарга (2007-2017)
- Монголын боловсролын сан, Ерөнхийлөгч, ТУЗ-ийн дарга (2012-одоог хүртэл)
- Мандал даатгал ХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2012-одоог хүртэл)
- Монголжин прайвит капитал, ТУЗ-ийн дэд дарга (2013-одоог хүртэл)
- Монголын хөгжлийн групп, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2014-одоог хүртэл)
- Голомт банк, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2017-одоог хүртэл)

АЛЕКСАНДР ПИКЕР

Боловсрол:

- Австри улсын Зальцбургийн ИС, Бизнес, Хуулийн чиглэлээр магистр, доктор (1982-1989)

Ажлын туршлага:

- Австри улсын Die ERSTE банк, Төслийн санхүүжилтийн ахлах ажилтан (1990-1993)
- Австри улсын хяналтын банк, ЗХУ харицсан ахлах ажилтан (1993)
- ОХУ-ын Москвагийн олон улсын банк, Байгууллагын банкны газрын ахлах менежер, Захирал, Эрсдэл хариуцсан захирал (1994-1999)
- Польш улсын BPH банк, Үйл ажиллагаа хариуцсан захирал, Эрсдэл хариуцсан захирал (1999-2004)
- Серби улсын Unicredit банк, Гүйцэтгэх захирал (2004-2007)
- Казакстан улсын JSC ATF банк, Гүйцэтгэх захирал (2007-2010)
- Европын Unicredit групп, Дэд ерөнхийлөгч (1994-2011)
- Нуро Alpe-Adria банкны Чех, Босни ба Херцеговина, Австри улс дах салбаруудын Гүйцэтгэх захирал (2011-2015)
- Итали улсын Нуро банк, ТУЗ-ийн дарга (2014-2015)
- Серби улсын Komercijalna банк, Гүйцэтгэх захирал (2015-2017)
- Transparency International-н Австрийн салбар, Гүйцэтгэх захирал (2018-2019)
- Герман улсын AlixPartners, Хараат бус гэрээт ажилтан (2018-2019)
- Австри улсын BCB4U, Гүйцэтгэх захирал (2019)
- Pendl & Piswanger, ТУЗ-ийн зөвлөх гишүүн (2019-одоог хүртэл)
- Дэлхийн банкны төслүүд, Ахлах зөвлөх (2019-одоог хүртэл)
- Австри улсын Крипто Бирж, Зөвлөх (2020-одоог хүртэл)
- Узбекистан улсын Ipoteka банк, Хяналтын зөвлөлийн дарга (2020-одоог хүртэл)
- Голомт банк, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2021-одоог хүртэл)

РОБЕРТ ЦВИТЕН – (Голомт банкны ТУЗ-д шинээр анх удаа нэр дэвшиж буй нэр дэвшигч)

Боловсрол:

- Нидерландын Хаант Улсын Лейдны ИС, Хуульч (1980-1986)
- АНУ-ын Колумбын их сургууль, Хууль зүйн магистр (1987-1988)
- Нидерландын Хаант Улсын Лейдны ИС, ОУ-ын эдийн засгийн магистр (1986-1991)
- АНУ-ын Чигако их сургууль, Бизнесийн удирдлагын магистр (1994-1996)



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Ажлын туршлага:

- НХУ-ын Royal Vopak, Хуульч, Евро бүсийн хариуцсан менежер, (1985-1990)
- ABN Amro Bank, АНУ, БНСУ, НХУ-ууды салбаруудад дэд ерөнхийлөгч (1990-1998)
- General electric, Санхүүч (1998-2002)
- Lehman brothers, Лондон, Нью-Йорк, Франкфурт, Токио салбаруудад Үйл ажиллагаа хариуцсан захирал (2002-2005)
- Сингапурын хөрөнгийн бирж, Санхүүч хариуцсан захирал (2006-2007)
- Стандарт банк, Сингапур салбар (2007-2008)
- Азийн хөгжлийн банк, Хувийн салбарын хөрөнгийн зах зээлийн салбарын захирал (2009-2012)
- АНУ-д төвтэй EMPEA, Гүйцэтгэх захирал, (2013-2017)
- АНУ-д төвтэй Serendra group, Гүйцэтгэх захирал, (2017-одоог хүртэл)
- БНПУ-д төвтэй Байгууллагын ТУЗ-ийн гишүүдийн институт, (2020-одоог хүртэл)
- БНПУ-д төвтэй Конвержинс, Үйл ажиллагааны захирал, Ахлах зөвлөх (2020-2022)
- Нидерландын Хаант Улсад төвтэй Дэлхийн бенчмаркийн нэгдэл, Төлөөлөгч (2020-одоог хүртэл)
- АНУ-д төвтэй Уур амьсгалын бодлогын санаачилга, Зөвлөлийн гишүүн (2022-одоог хүртэл)
- PwC Зүүн Өмнөд Ази Консалтинг, Үйл ажиллагаа хариуцсан захирал (2022-одоог хүртэл)

Хурлын дарга Г.Ганболд: ТУЗ-д нэр дэвшиж байгаа ихэнх гишүүд хуучин ажиллаж байсан хүмүүс байгаа. Манай дотоодоос нэр дэвшиж байгаа хүмүүс энэ танхимд байгаа асуулт асууж болно. ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо кумулятив аргаар сонгоно. Та бүхэнд тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Тогтоолын төсөл

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 сарын 26-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан дор дурдсан нэр дэвшигчдийг “Голомт банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр 2024 оны ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл сонгосугай.

Хурлын дарга Г.Ганболд: Та бүхэнд асуулт байхгүй бол одоо Төлөөлөн удирдах зөвлөлийн болон Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааны журмыг танилцуулна.

Хэлэлцэх асуудал 7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааны журам, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг танилцуулж батлах.

Танилцуулсан нь:

Хуулийн хэлтсийн захирал Г.Ганбат: Нийт хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэндийг хүргэе. Та бүхэнд ТУЗ-ийн болон ХЭХ-ын үйл ажиллагааны журмыг товч танилцуулна. Журмын зорилго компанийн тухай хууль болон зохицуулагч байгууллагууд болох Монголбанк, СЗХ, МХБ-с гаргасан дүрэм журам, хууль, засаглалын кодекст заасан заавал батлах баримт бичгийн нэг байгаа.

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааны журмыг танилцуулав:



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ



Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааны журам



Хууль тогтоомж:

1. Компанийн тухай хууль;
2. Банкны тухай хууль;
3. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж зэрэг зохицуулагч байгууллагуудын холбогдох журам, компанийн засаглалыг кодекст нийцсэн.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг танилцуулав:



Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам



Хууль тогтоомж:

1. Компанийн тухай хууль;
2. Банкны тухай хууль;
3. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журам, компанийн засаглалыг кодекст нийцсэн.

Хурлын дарга Г.Ганболд: Батлах ТУЗ-ийн тогтоолыг уншиж танилцуулъя.

Тогтоолын төсөл

Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааны болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг батлах тухай

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, Голомт банкны дүрмийн 8.2.12 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 сарын 26-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Голомт банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааны журмыг Хавсралт №1-ийн дагуу, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг Хавсралт №2-ын дагуу тус тус баталсугай.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Хурлын дарга Г.Ганболд: Сүүлд хэлэлцсэн 4 асуудалтай холбоотой асуулт байна уу?

Асуулт байхгүй байх шиг байна. Тооллогын комиссын дарга санал өгөх заавар өгнө үү.

Тооллогын комиссын дарга Б.Баатар: Санал хураалтын үргэлжлэх хугацаа 15 минут байгаа. Зааврын дагуу та бүхэн онлайнаар саналаа өгөх боломжтой. Манай ажилтнууд та бүхэнд тусална. Энэ хооронд гадаа кофе завсарлага байгаа та бүхэн чөлөөтэй саналаа өгөөрэй. Бид саналыг онлайнаар хүлээж авах учир удахгүй байх гэж найдаж байна. Баярлалаа.

Хурлын дарга Г.Ганболд: Санал өгөх хугацааг нээснийг мэдэгдье. 15 минутын завсарлага өгч байна. Асуудал гарвал манай ажилтдад хандаарай.

Санал хураалт, кофе завсарлага: 15 минут

Саналын тооллогын процесс: 10 минут

Тооллогын комиссын үр дүн:

Хурлын дарга Г.Ганболд: Санал тоолох процесс дууссан байна. Санал хураалтын дүнг Баатар захирал танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Б.Баатар: Тооллогын комиссын тогтоолыг танилцуулъя. Өглөө 09:00 цагийн байдлаар ирц авахад 88.45 хувийн ирцтэй байсан бол өнгөрсөн цаг хугацаанд нэмэгдээд 90.03 хувь болж ирц нэмэгдсэн. Нийт 728,048,953 ширхэг хувьцааг эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид саналаа өгсөн байна. Компанийн тухай хуулийн 67-р зүйлийн 67.3.8 хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн тогтоох нь. Ердийн аргаар нийт 3 санал хураалт явуулсан.

1. “Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах”

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
718,988,893	98.76%	0	0.0%	9,060,060	1.24%

2. “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны төсвийг батлах”

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
718,819,629	98.73%	168,798	0.02%	9,060,526	1.24%

3. “Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааны журам, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журмыг батлах”

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
718,987,579	98.76%	0	0.0%	9,061,374	1.24%

4. “ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай”

Ердийн гишүүд:

Ч.Мөнхцэцэг - 720,807,943

Ж.Үнэнбат - 724,380,249

Д.Мөнхтөр - 717,588,269

О.Ганжолоо - 728,429,170



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Урс Э.Шварценбах - 716,214,145

Хараат бус гишүүд:

Жэймс Б.Двайер - 716,618,972

Антонио Л.Абелло - 716,954,764

Александр Пикер - 716,506,667

Роберт Цвитен - 716,327,881


Түдгэлзсэн саналын тоо: 78,612,517

Хурлын дарга Г.Ганболд: Хурлыг хаав. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх 7 асуудлыг амжилттай хэлэлцэж, 4 шийдвэрээ 98.7 хувиас дээш саналтайгаар баталж баталгаажууллаа. Онлайнаар хуралд оролцож байгаа болоод өнөөдөр цаг зав гарган хүрэлцэн ирсэн эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч та бүхэнд банкны удирдлагын нэрийн өмнөөс талархал илэрхийлье. Голомт банкны бизнесийн гол концепци бол нээлттэй банк. Бид үйл ажиллагааны хувьд, засаглалын хувьд, санхүүгийн хувьд, мөн технологийн хувьд ч нээлттэй зарчмыг барьж, аль болох хамгийн хүртээмжтэй санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээр зорьж байгаа. Та бүхний эрхэлж байгаа ажил үйлст өндөр амжилт хүсэж, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсье. Дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл баяртай. Баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэхээр төлөвлөсөн 7 асуудлаас бүгд долоон асуудлыг хэлэлцэж хурлыг 12:10 минутад хаав.

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦАЖ БАТАЛСАН:

Хурлын Дарга

 Г. Ганболд

ТЭМДЭГЛЭЛ ХЯНАЖ БЭЛТГЭСЭН:

Нарийн бичгийн дарга

 З. Солонго